



НИЙСЛЭЛИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/50

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйл, 6 дугаар зүйлийн 6.8.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн Газрын “Журам шинэчлэн батлах тухай” 2020 оны 217 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаал, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд санал боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

М.Цогзолмаа

Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга

Ажлын хэсгийн гишүүд:

Э.Мөнх-Эрдэнэ

Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Б.Оюунтуяа

Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Н.Өлзийжаргал

Хэвлэл мэдээлэл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Ажлын хэсгийн нарийн

Г.Бямбасайхан

бичгийн дарга:

Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

2.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд санал боловсруулахдаа биеийн тамир, спортын салбарын байгууллагууд болон иргэдээс санал авч, урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан байгууллагын үйл ажиллагааны суурь судалгаа, статистик тоо баримтад үндэслэж зорилт, зохион байгуулах арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин, санхүүжилтийг тооцож төлөвлөн 2024 оны 12 дугаар сарын 22-ны өдрийг хүртэлх хугацаанд боловсруулж байгууллагын удирдлагад танилцуулахыг Ажлын хэсэг (М.Цогзолмаа)-т үүрэг болгосугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсэг (М.Цогзолмаа)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.САРАНЦЭЦЭГ